



ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

*Илтгэгч: Статистикийн хэлтсийн
даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Д.ТУНГАЛАГ*

<http://www.govi-altai.nso.mn/>

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ - Үндсэн үзүүлэлт

Үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2015	2016	$\frac{2016\%}{2015}$
Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд				
Хүн амын тоо	тоо	56018	56694	101.2
Өрхийн тоо	тоо	16072	16254	101.1
Бүтэн өнчин хүүхдийн тоо	тоо	57	49	86.0
Хагас өнчин хүүхдийн тоо	тоо	1030	968	94.0
Өрх толголсон эмэгтэйчүүдийн тоо	тоо	2386	2383	99.9
Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо	тоо	2220	2158	97.2
Хүн амын амжиргааны доод түвшин	мян.төг	164.2	164.8	100.4
Төрсөн хүүхдийн тоо /амьд төрөлт/	тоо	1293	1176	91.0
Нас баралтын тоо	тоо	277	309	111.6
Эхийн эндэгдэл	тоо	-	-	-
Халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо	тоо	416	964	231.7
Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо	тоо	1044	786	75.3



ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠢ ᠨᠢᠶᠭᠦᠮ, ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠨ ᠪᠠᠶᠳᠠᠯ - Үндсэн үзүүлэлт



ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠯᠤᠯᠤᠰ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ - Үндсэн үзүүлэлт

Үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	2015	2016	$\frac{2016\%}{2015}$
Макро эдийн засгийн статистик үзүүлэлтүүд					
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт		хувь	102.6	103.6	101.0
Татварын орлого		сая.төг	4966.2	5733.8	115.5
Аймгийн нэгдсэн төсвийн зарлага		сая.төг	52466.7	58033.3	110.6
Нийт малын тоо		толгой	2922571	3497492	119.7
Үүнээс	Адуу	толгой	88369	106843	120.9
	Үхэр	толгой	58822	71058	120.8
	Тэмээ	толгой	34741	38540	110.9
	Хонь	толгой	909312	1107114	121.8
	Ямаа	толгой	1831326	2173937	118.7
Төллөсөн хээлтэгч		толгой	983540	1108884	112.7
Бойжуулсан төл		толгой	945639	1080628	114.3

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ - Үндсэн үзүүлэлт

Үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	2015	2016	$\frac{2016}{2015}\%$
	Мал онд оролт	хувь	99.4	98.8	99.4
	Хорогдсон том мал /бүгд/	толгой	16223	35131	216.6
Үүнээс	Тэмээ	толгой	516	641	124.2
	Адуу	толгой	488	915	187.5
	Үхэр	толгой	246	187	76.0
	Хонь	толгой	4764	8280	173.8
	Ямаа	толгой	10209	25108	245.9
	Өвчнөөр хорогдсон том мал	толгой	1415	1291	91.2
	Хээлтэгч малын хорогдол	толгой	3172	6382	201.2
	Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт /бүгд/	сая.төг	13488.5	13223.1	98.0
Үүнээс	Цахилгаан	сая.төг	5564.5	5302.8	95.3
	Дулаан	сая.төг	4383.5	4131.7	94.3
	Усан хангамж	сая.төг	747.3	944.7	126.4
	Боловсруулах үйлдвэр	сая.төг	1689.8	1667.5	98.7
	Олборлох үйлвэрлэл	сая.төг	1103.4	1176.4	106.6




ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠢ ᠨᠢᠶᠭᠦᠮ, ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠦᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ - Үндсэн үзүүлэлт



ᠮᠤᠩᠭᠤᠯᠤᠯᠤᠰ
ᠤᠯᠠᠳᠤ
ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ
ᠰᠤᠯᠡᠲᠦᠰ


Хүн амын нас, хүйсийн суварга

Population pyramid of Govi-Altai




2016 оны эцэст манай аймгийн хүн 56694 байна. Нийт хүн амыг нас хүйсийн суваргаас харахад 0-39 насны хүн амд эрэгтэйчүүдийн эзлэх хувь илүү байхад 40-с дээш насныханд эмэгтэйчүүдийн эзлэх хувь их байна. Аймгийн хэмжээнд 70 дээш насны 1446 өндөр настан байгаагийн 65.6 хувь нь эмэгтэйчүүд байна. 2016 оны эцсээр аймгийн хэмжээнд 97-с дээш насны 3 өндөр настан байгаа бөгөөд 3-лаа эмэгтэй хүн байна

ХҮН АМЫН ТОО, байршлаар




Аймгийн төвд 5053 өрхийн 17137 хүн, сумын төвд 3900 өрхийн 14267 хүн, тосгонд 306 өрхийн 927 хүн амьдарч байна. Хөдөөд 6995 өрхийн 24363 хүн амьдарч байгаа нь нийт хүн амын 42.9% байна.

Хүн ам байршлаар, эмэгтэйчүүдийн эзлэх хувь



ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠢ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢ ᠬᠡᠯᠲᠡᠰ

ӨРХИЙН ТОО /HOUSEHOLDS/, сумаар 2016 он




ᠮᠤᠩᠭᠡᠨᠠᠯᠲᠤᠢ ᠶ᠋ᠢᠨ ᠰᠤᠲᠤᠰᠲᠡᠭᠦᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ




ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢ ᠬᠡᠯᠲᠡᠰ

ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд


Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эцсийн байдлаар



Эндсэн хүүхэд, жил бүрийн эцсийн байдлаар



Халдварт өвчнөөр өвчлөгчид, жил бүрийн эцсийн байдлаар



Аймгийн хэмжээнд 2016 оны эцэст 1176 эх амаржиж, 1176 хүүхэд мэнд төрлөө. ӨМҮ-с амаржсан эх 108 буюу 8.4 хувиар, хүүхэд 117-оор буюу 9.0 хувиар буурсан байна. Нялхасын эндэгдэл 19 болж, ӨМҮ-с 2 буюу 11.7 хувиар, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 5 тохиолдол бүртгэгдэж ӨМҮ-с 2 тохиолдлоор нэмэгдсэн байна. Халдварт өвчнөөр өвчлөгчид 2016 оны эцэст 964 болж, ӨМҮ-с 548 буюу 2.3 дахин нэмэгджээ. Халдварт өвчлөл нэмэгдэхэд улаан бурхнаар өвчлөгчид ӨМҮ-с 599 буюу 17.2 дахин, салхин цэцгээр өвчлөгчид 76 буюу 5.8 дахин, гар хөл амны өвчин 16 буюу 4.2 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна.



ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠯᠤᠯᠤᠰ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ

ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Боловсрол




Ерөнхий боловсролын 28 сургууль, 28 цэцэрлэгт өсвөр үеийг сурган хүмүүжүүлж байна. ЕБСургуулиудад 11.3 мянган сурагч суралцаж, цэцэрлэгт 4.4 мянган хүүхэд хүмүүжиж байна. Энэ хичээлийн жилд нэгдүгээр ангид 1110 хүүхэд элсэн суралцаж байна.




ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Нийгмийн зарим үзүүлэлт


Бүтэн, хагас өнчин хүүхдийн тоо, жил бүрийн эцсийн байдлаар



Өрх толгойлсон эхийн тоо, жилийн эцсийн байдлаар



Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, жил бүрийн эцсийн байдлаар



Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 24.1 хувь нь хөдөлгөөний бэрхшээлтэй, 10.1 хувь нь сонсгол, 4.2 хувь нь хэл ярианы согогтой, 6.2 хувь нь хавсарсан согогтой, 10.8 хувь нь харах эрхтний өөрчлөлттэй, 28.0 хувь нь бусад, 16.6 хувь нь сэтгэцийн эмгэгтэй хүмүүс байна.


ᠬᠤᠨ ᠠᠮ, ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ ᠤᠵᠦᠭᠦᠯᠡᠯᠲᠤ – ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ ᠵᠠᠷᠢᠮ ᠤᠵᠦᠭᠦᠯᠡᠯᠲᠤ



ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠯᠢ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй

Малын тоо сумаар, мянган толгой



	2012	2013	2014	2015	2016
Бүгд	1911.0	2223.2	2578.1	2922.6	3497.5
Адуу	55.0	65.3	76.7	88.4	106.8
Үхэр	29.5	39.4	49.4	58.8	71.1
Тэмээ	28.2	30.4	32.8	34.7	38.5
Хонь	578.1	679.0	798.2	909.3	1107.1
Ямаа	1220.2	1409.1	1621.0	1831.3	2173.9




2016 оны жилийн эцсийн мал тооллогоор 3497.5 мянган толгой мал тоологдсоны дотор адуу 106.8 мянган толгой, үхэр 71.1 мянган толгой, тэмээ 38.5 мянган толгой, хонь 1107.1 мянган толгой, ямаа 2173.9 мянган толгой мал тус тус тоологджээ. Малын нийт тоо өмнөх оноос 574.9 мянга буюу 19.6 хувиар өссөний дотор адуу 18.4 мянга буюу 20.8 хувь, үхэр 12.3 мянга буюу 20.9 хувь, тэмээ 3.8 мянга буюу 1.1 хувь, хонь 197.8 мянга буюу 21.8 хувь, ямаа 342.6 мянга буюу 18.7 хувиар тус тус өсчээ. Улсад нийт тэмээ болон ямааны тоогоор 3-р байранд, мянгат малчдын тоогоор 5-р байранд тус тус оржээ. Малтай 9932 өрх байгаагийн 6903 нь малчин өрх байна. Мөн энэ онд 1000 түүнээс дээш малтай өрхийн тоо 646 болж өнгөрсөн оноос 226 өрхөөр нэмэгджээ.




ᠡᠳᠢᠶ᠋ᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠶ᠋ᠢᠨ ᠤᠵᠠᠭᠤᠯᠡᠯᠲᠤ – ᠬᠡᠳᠡᠭᠡ ᠠᠵᠤ ᠬᠤᠭᠤ

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй


Хураасан үр тариа, жил бүрийн эцэст, тн-оор




Хураасан төмс, хүнсний ногоо, тн-оор



Хураасан тэжээлийн ургамал, жил бүрийн эцэст, тн-оор



Бэлтгэсэн өвс, гар тэжээл, жил бүрийн эцэст, тн-оор



Энэ оны эцсийн байдлаар үр тариа 525.3 тн, төмс 633.1 тн, хүнсний ногоо 468.8 тн, малын тэжээлийн ургамал 1479 тонныг тус тус хурааж аваад байна. Мөн 5169.3 тн байгалийн хадлан, 283.2 тн гар тэжээл, 2879.5 тн хужир шүү тус тус бэлтгэсэн байна.


МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, жил бүрийн эцэст, сая төг

Аж үйлдвэрийн салбар	2014	2015	2016	$\frac{2016}{2015}$	%
Нийт дүн	10818.4	13488.5	13223.1	98.0	
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	1537.2	1103.4	1176.4	106.6	
Боловсруулах аж үйлдвэр	1628.1	1689.8	1667.5	98.7	
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	7653.1	10695.3	10379.2	97.0	

Өмнөх оны мөн үеийнхээс 265.4 сая төг буюу 1.97 хувиар буурлаа. Үүнд олборлох аж үйлвэрийн салбар 6.6 хувиар өссөн хэдий ч, боловсруулах аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 22.3 сая төг буюу 1.3 хувиар, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл усан хангамжийн салбарын нийт үйлдвэрлэл 316.1 сая төг буюу 2.99 хувиар буурсан нь голлон нөлөөлөв.

Аж үйлдвэрийн салбарын борлуулалт, дэд салбараар, оны үнээр, дүнд эзлэх хувиар



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2016 оны байдлаар 11 тэрбум 466.1 сая төг бүтээгдэхүүн борлуулжээ.

2014


2015

2016

- Уул уурхай, олборлох аж үйлдвэр
- Боловсруулах аж үйлдвэр
- Цахилгаан, дулаан эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж

2016 ОНЫ ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Төсвийн орлогын бүтэц, хувиар 2016 оны I-XII сард



Төсвийн орлого: Орон нутгийн төсөвт 53 тэрбум 22.7 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 90.9 хувиар биелүүлж, аймгийн орлогын албан татвар 5 тэрбум 733.8 сая төгрөгийн орлого олж төлөвлөгөөг 109.2 хувиар биелүүлсэн байна. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 8 дахин, байгалийн нөөц ашигласны төлбөр 4 дахин, Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 2 дахин, нохойны албан татвар 4 дахин, төсөвт байгууллагын өөрийн орлого 8 дахин, түрээсийн орлого 2 дахин давуулан биелсэн байна. Татварын орлогын төлөвлөгөөг Алтай, Баян-Уул, Бигэр, Дарив, Цогт, Шарга сумууд 2-5 дахин, Бугат, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цээл, Чандмань, Эрдэнэ сумд 3.9-186.3 хувиар давуулж, бусад сумууд 10.41-11.4 хувиар тасалсан байна.

2016 ОНЫ АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсвийн зарлагын бүтэц, хувиар 2016 оны I-XII сард



Төсвийн зарлага: Орон нутгийн төсвийн зарлагыг 58 тэрбум 33.3 сая төгрөгөөр буюу 99.5 хувийг санхүүжүүлэв. Үүнд цалин хөлс нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 99.2, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 99.5, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын 107.5, хангамж бараа материалын зардал 104.4, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 109.9, бараа үйлчилгээний бусад зардал 114.3, эд хогшил, урсгал засварын зардал 132 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.

Үнэ

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИНДЕКС, бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	<u>2016-12</u> 2010-12	<u>2016-12</u> 2015-12	<u>2016-12</u> 2016-11
Ерөнхий индекс	100	155.0	103.6	100.3
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	144.2	105.3	100.5
Согтууруулах ундаа, тамхи	3.2	221.5	99.8	100.0
Хувцас, бөс бараа, гутал	16.1	163.5	104.1	100.3
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	146.2	104.1	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	154.4	105.4	100.0
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	118.7	100.0	100.0
Тээвэр	12.2	136.3	98.3	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	96.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	110.6	99.4	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	393.6	109.1	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	192.5	103.5	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	140.3	98.6	100.0


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс Говь-Алтай аймгийн хэмжээнд 2016 оны 12 дугаар сард өмнөх сараасаа 0.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 3.6 хувь, сүүр үеийнхээс 55.0 хувиар өсчээ. Ерөнхий индекс 2016 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 0.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн индекс 0.5, хувцас, бөс бараа, гутал 0.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Энэ бүлгийн үнийн индекс өсөхөд тухайн бүлэгт өндөр хувийн жин эзэлдэг мах 500-800 төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Үнэ

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2016 оны 12 дугаар сард өмнөх оны жилийн эцсээс 3.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, ус 5.3, хувцас, бөс бараа, орон сууц, ус, цахилгаан, түлш 4.1, гэр ахуйн тавилга, бараа 5.4, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.




Хэрэглээний үнийн индекс
(өмнөх оны 12 сар=100)



Үнэ

Махны үнэ, 7 хоногоор, төг



Махны дундаж үнэ: 2017 оны 1-р сарын 11-ны байдлаар хонины махны үнэ өмнөх сарынхаас 25.9 хувь, үхрийн цул махны үнэ 18.9 хувь, ямааны махны үнэ 18.5 хувиар өссөн байна. Өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад махны үнэ тогтвортой байна. 2017 оны 1-р сарын 11-ны байдлаар 1 кг хонины мах дунджаар 4500 төгрөг, үхрийн цул мах 5800 төгрөг, ямааны /ястай/ мах 3200 төгрөгийн үнэтэй байв.


Мөнгө, банк

Мөнгөний нийлүүлэлт /M2/ 2016 оны 12 дугаар сарын эцэст 69.2 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 4.7 тэрбум төгрөг буюу 7.2 хувиар өсчээ.

Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст сая төг

Үзүүлэлт	2016	
	IX	XII
Мөнгөний нийлүүлэлт M2	64529.4	69205.0
Сарын өөрчлөлт, хувиар	1.2	7.2
Нийт хадгаламж	55184.9	58826.7
Сарын өөрчлөлт, хувиар	1.4	6.6
Төгрөгийн хадгаламж	54103.3	57960.7
Сарын өөрчлөлт, хувиар	1.7	7.1
Валютын хадгаламж	1081.5	866.0
Сарын өөрчлөлт, хувиар	56.2	-19.9


Чанаргүй зээл, сарын эцэст, сая төг



Чанаргүй зээл 2016 оны 12 дугаар сарын эцэст 1.5 тэрбум төгрөг болж өмнөх сарынхаас 64.2 сая төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.7 хувийг эзэлж байна.

2016 ОНЫ ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН ГҮЙЦЭТГЭЛ


■ Барилга угсралт, их засвар /сая.төг/ ■ Авто зам /сая.төг/



Барилга: Барилга угсралт, их засварын нийт 12 тэрбум 121.5 сая төгрөгийн ажил хийж, үүнээс 10 тэрбум 806.9 сая төгрөгийн шинэ барилга, 1 тэрбум 314.6 сая төгрөгийн их засварын ажлыг гүйцэтгэсэн байна. Говь-Алтай Ховд аймаг хоорондын 165 км хатуу хучилттай авто замыг 116 тэрбум 298.1 сая төгрөгөөр, нисэх буудлын хатуу хучилттай замыг 492.0 сая төгрөгөөр тус тус барьсан нь энэ салбарын өсөлтөд голлон нөлөөлжээ.

2016 ОНЫ ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, сумаар


- Иргэд, байгууллагад учруулсан хохирол /сая.төг/ Хохирол нөхөн төлөлт
- Хохирол нөхөн төлөлт /сая.төг/




Гэмт хэрэг: Байгууллага, иргэдийн 311.4 сая төгрөгийн өмч хөрөнгөнд хохирол учруулж, 183 гэмт хэрэг гарч, эдгээр хэргүүдээс хулгай гэмт хэрэг, үүнээс тээврийн хэрэгсэл болон орон байрны хулгай, хүчин, дээрэм булаалт, ББМБГУчруулах гэмт хэргүүд дийлэнх буюу 75.9 хувийг эзэлж байна. Гарсан нийт хэргийн 62.8 хувь нь Алтай хот буюу Есөнбулаг сумд гарсан хэрэг эзэлж байна. Гэмт хэрэгт холбогдогчид 214, үүнээс эмэгтэй 19, хүүхэд 12, ажил мэргэжилгүй 92 хүн бүртгэгдсэн байна. Гэмт хэргийн улмаас нас барсан 8 хүн, урьд шийтгүүлсэн 19 хүн, баривчлагдсан 159 хүн, саатуулагдсан 636 хүн, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасуулсан 176 хүн бүртгэгджээ.

2016 ОНЫ АЙМГИЙН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

- Харилцаа холбооны үйлчилгээний орлого /мян.төг/
- Хүн амаас олсон орлого /мян.төг/



- Суурин утасны цэгийн тоо
- Хүн амын суурин утасны цэгийн тоо



Интернет хэрэглэгч 596 байгууллагад ADSL болон шилэн кабелийн интернетээр үйлчилжээ. Суурин телефон цэгийн тоо 748, холбоо ашиглалтын орлого 258.3 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 180.9 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Интернэтийн үйлчилгээний нэг цэг 20 суудалтай ажиллаж интернэтээр дунджаар 2.7 мянган хүнд үйлчилжээ.

ᠮᠣᠩᠭᠡᠯᠡᠭᠡᠨ ᠰᠤᠮᠤᠯᠤᠯᠤᠯᠤᠰᠤ ᠶᠡᠬᠡᠨ ᠰᠤᠮᠤᠯᠤᠯᠤᠯᠤᠰᠤ

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Говь-Алтай аймаг, Засаг даргын
дэргэдэх Статистикийн хэлтэс**

Утас : (7048-4278)

(7048-3442)

Э-майл : stat_altai@yahoo.com



ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠢᠨ ᠰᠤᠲᠤᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ